ЗУНЫ АЖЛЫН ХУВЦАСНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ажлын тусгай хувцас нийлүүлэх үйлдвэр, аж ахуйн нэгж салбарын холбогдох удирдлагууд дараах стандартыг дагаж мөрдөнө.

Энэ стандартад дараах хүчин төгөлдөр мөрдөж буй стандартуудыг ишлэл болгов. Иш татсан стандартууд дахин хянагдаж өөрчлөгдвөл хамгийн сүүлийн хувилбар эсвэл доорх стандартуудтай дүйцхүйц стандарт мөрдөнө. Үүнд:

- MNS ISO 13688:2000 Ажлын тусгай хувцас – ерөнхий шаардлага
- ISO 105- Нэхмэл бүтээгдэхүүний өнгө тогтворжилтын сорилт
- ISO 317:1995 Машинаар хуурайгаар нь цэвэрлэх үед хэмжээний өөрчлөлтийг тогтоох
- ISO 3635 Хувцасны хэмжээний тэмдэглэгээ-хэмжээг тодорхойлох ба авах
- ISO 3758 Нэхмэл бүтээгдэхүүн –хэрэглэгчдэд зориулсан тэмдгийг шошгонд кодлох
- ISO-9237 Агаар нэвтрүүлэлт, агаарын эзэлхүүн,агаарын хэмжээ
- ISO 12947-2 Элэгдэл тэсвэрлэлт
- MNS ISO 1835 -3:2007Нэхмэл бүтээгдэхүүн. 1м^2-ийн жин тодорхойлох арга
- MNS ISO 1835 -4:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Зузаан тодорхойлох арга
- MNS ISO 1835-5:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Нэхээсний нягт тодорхойлох арга
- MNS ISO 1835-6:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Тасрах үеийн даац суналт
- MNS ISO 1835-7:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Усны үйлчлэл тодорхойлох арга
- MNS ISO 1835 -9:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Норгосны дараах хэмжээний өөрчлөлт тодорхойлох арга
- MNS ISO 1835 -13:2007 Нэхмэл бүтээгдэхүүн. Үрэлт тэсвэрлэлт тодорхойлох арга
- MNS ISO 4010:97 Цэвэр ба хагас ноосон ээрмэл даавуу. Ноосны агуулгыг тодорхойлох арга
- MNS ISO 4072 : 1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг угаалгад тодорхойлох арга
- MNS ISO 4069:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хөлсөнд тодорхойлох арга
- MNS ISO 4069:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хуурай нойтон байдал үрэлтэд тодорхойлох арга
- MNS ISO 4073:1988 Нэхмэл материал. Будгийн тогтворыг хими цэвэрлэгээнд тодорхойлох арга
- MNS 4010-2009- Ширхэгтийн бүрэлдэхүүн
-

1.ТОДОРХОЙЛОЛТ

1.1.Ажлын тусгай хувцас

Ажлын тусгай хувцасны дизайн, үйлдвэрлэл дараах шаардлагыг хангасан байна.

1.1.1.Ажлын тусгай хувцас нь “Ажлын тусгай хувцас – ерөнхий шаардлага MNS 13688:2000” Монгол улсын стандартын шаардлагыг хангасан байна.
1.1.3.Бат бөх хийгдсэн, эдийн засгийн үр ашигтай байна.
1.1.4.Хувцасны материал нь эрх бүхий байгууллагаар шалгагдаж баталгаажсан байна.

1.1.5.Хувцасны материал, бүрдэл хэсгүүд нь хүнд саад болохгүй байх
1.1.6.Хувцасны дизайн нь хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байх
1.1.7.Хөдөлгөөн болон гадаад орчны хүчин зүйл, сөрөг нөлөөллийг тооцсон хэрэглээний хугацааг урьдаас тооцож баталгаажуулсан байх
1.1.8.Ажлын тусгай хувцсыг үйлдвэрлэснээс хойш 2-оос доошгүй жил ердийн нөхцөлд хадгалсны дараа тэдгээрийг ашиглах боломжтой байх
1.1.9.Хувцасны масс нь түүнийг өмсөж байгаа хүний ая тухыг хангах ба биеийн хүчний ачааллыг багасгахын тулд бололцооны хирээр бага байна.

1.2. Ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага

1.2.1.Ажилтнуудын хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалсан ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага
1.2.2 Хэрэглээний дараа цэвэрлэхэд хялбар байх. Энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байх
1.2.3 Ус,тос, масло нэвтрүүлэхгүй байх
1.2.4. Хөдөлгөөн хийхэд саадгүй. Биед дээд зэргээр таардаг байх.
1.2.5. Төмөр буюу металл гадаргуутай хүрэлцэх үед хувцас нь цахилгаанжихгүй, үрэлтэд гэмтэх, цооролт өгөхгүй.
1.2.6. Хүний биед харшлахгүй байх.
1.2.7. Ажлын үед шаардлагатай багаж хийх халаас,өндрөөс унахаас хамгаалах бүс зүүх бололцоотой байх. Дээшээ авирах болон биеийн суусан болон бөхийх үед хөдөлгөөнд саад болохоргүй байна.
1.2.8. Өндрөөс унахаас хамгаалах бүс зүүх үед хувцасны хүний биед хүрэлцэх хэсгүүд нь аливаа цочроо, шархлаа, бие барилт үүсгэхгүй байх, бүрдэл хэсгүүд саад болохгүй байх
1.2.9. Цахилгаанжихгүй, болзошгүй цахилгаан нумын түлэгдэлт, галын үед хувцасны бүрдэл хэсэг хүний биед наалдахгүй. Хүний биетэй шүргэлцэх хэсэг цэвэр даавуугаар хийгдсэн байна.
1.2.10. Хязгаарлагдмал ажлын талбай буюу хөдөлгөөнтэй машин техник, элементүүдэд орооцолдохгүй байх
1.2.11. Өвдөг тохой, өгзөгийн хэсгээр нэмэлт давхарлагаатай байна
1.2.12. Харанхуй, гэрэлтүүлэг муутай үед хүний нүдэнд өртөх зорилгоор цээж болон нурууны ар хэсгээр гэрэлтдэг оруулгатай байна. 1.2.13. Оруулгын өнгө саарал байна.

Хүснэгт-1

	Хүрэм		Өмд
	үндсэн	Нэмэлт /оруулга/	
Монтёр хувцас	Хар хөх	улаан	Хар хөх
Халад, өмд +цамц	Цагаан	-	цагаан
“Үйлчлэгч”	Цайвар чернилэн ягаан	-	Гүн чернилэн ягаан

1.3. Ажлын тусгай хувцасны загвар болон зохион бүтээлт

Ерөнхий шаардлага

Хувцасны загвар ба хэмжээ нь өмсөх хүний ая тухыг боломжтой байдлаар хангах, хувцасны зохион бүтээлт нь түүнийг өмсөх үед биед эвтэйхэн, ажил хөдөлмөр эрхлэхэд саад болохгүй байна.

Хөдөлгөөний чөлөөтэй байдлыг хангах оёдол, зохион бүтээлт, зүсэлт нь 1-р зурагт үзүүлсний дагуу байна.



Зураг 1. Гарын чөлөөт хөдөлгөөнийг хангах оруулга

2.Ажлын тусгай хувцасны төрлүүд

2.1. Монтёр хувцас

2.1.1.“Монтёр” хувцасаар хангагдах хэсэгт орсон ажилтнуудын хүрэмний хийцэд дараах зохион бүтээлт, хийцүүдийг тусгасан байна./Зураг №2-д үзүүлэв/

а/ Зах нь наалддаг товчоор босоо байрлалд ордог.

б/ Энгэрийн дээд хөндлөн оруулгатай. Оруулга нь улаан өнгөтэй.

в/ Залгаа ханцуйтай,ханцуйны манжет нь наалддаг товчтой чангарах боломжтой.

г/ Цамцны /цахилгаан/ товч нь далд цахилгаан товчлоостой. Дардаг даравчтай байна. Даравч нь зангуу товчоор наалддаг байна.

д/ Энгэр болон ташаанд тагтай ил халаастай

е/ Цамц нь энгэртээ болон 2 хажуу талдаа урт халаастай байх. Халаас нь эзэлхүүнтэй байх.

ё/ Ханцуй нь ажил гүйцэтгэх үед хөдөлгөөнд саад учруулахааргүй байх ба далны хэсэгт давхар оруулгатай байна.

ж/ Цамцны ар тал нь захны залгааснаас доош 15 см орчим, урд тал нь мөрний залгааснаас энгэрийн халаас хүртэл улаан өнгөтэй байна. Ханцуй нь хөх өнгөтэй байна.

з/ Зүүн ханцуйн мөрний залгаасаас доош 10 см орчимд компанийн логоны дээд ирмэг байхаар оёно.
и/ Цамцны ар талд залгааснаас доош 1 см-т УБЦТС ХК гэж шар өнгөөр 4.5 см өндөртэй үсгээр бичнэ. Үсэгний өргөн 0,5 см байна.
й /Цамцны бүсэлхий хэсэг нь дотроо бүстэй чангалдаг байх. Далд бүстэй.
к /Сугандаа агааржуулагч гуурстай байна.

Зураг 2

2.1.2.Монтёр хувцасаар хангагдах хэсэгт орсон ажилтнуудын өмдний хийцэд дараах зохион бүтээлт, хийцүүдийг тусгасан байна. /3-р зурагт үзүүлэв/
а/ Өвдөгний хэсэгт давхарлагатай, өвдөгөнд хуниастай байх.
б/ Арын суудлын хэсэгт давхарлагатай
в/ Ташааны оёдолд орсон халаастай, 2 хажуу талдаа халаастай, сууж ажил гүйцэтгэхэд тохиромжтой
г/ Хажуу талд тагтай эзэлхүүнтэй халаастай
д/ Шуумагны товчоор нарийсах боломжтой байна.



Зураг №3 Зуны өмдний хийц

2.2. Халад, өмд +цамц хэсэгт орсон ажилтнуудын хувцасны загвар, хийцэд дараах зохион бүтээлт, хийцүүдийг тусгасан байна. /Зураг №4-т үзүүлэв/

а. Ар, энгэр хажуу ханцуй гэсэн 3-н бүрдэл хэсэгтэй.
б. Хагас богино урттай
в. Эргэсэн хэвтээ захтай
г. Энгэр дан зөрлөгтөй
д. Зүүн энгэрийн дээд хэсэгт халаастай
е. Энгэрийн доод хэсэгт хоёр ил халаастай
ё. Нэг оёдолтой,залгаатай ханцуйтай
ж. Энгэр,бартаа зах 0.5 см-ийн ил гоёлын оёдолтой
з. Ханцуй үзүүр 2см өргөн нугалж оёсон
и. Ар голд өргөн оёдолтой
й. Ар голд оноотой
к. Энгэрт 4н ширхэг товчтой
л. Хормойг 2см өргөнтэй нугалж оёсон

Зураг №4.

<u>Халад, өмд +цамц 2-р хэсэгт</u> орсон эмчийн (Зураг 5) халатны загвар, хийцэд дараах зохион бүтээлт, хийцүүдийг тусгасан байна.

а.Ар,энгэр мөрнөөс гарсан босоо релефтэй
б.Энгэр гурвалжин захтай
в.Энгэрийн оруулганд хавчуулж оёсон хоёр ил халаастай
г.Ил халаасны ирмэг 2 см нугалж оёсон гоёлын оёдолтой
д.Зүүн энгэрийн дээд хэсэгт ил халаастай
е.Жижиг халаасны ирмэг 2 см нугалж оёсон гоёлын оёдолтой
ё.Өвдөг хүрсэн урт загвартай
ж.Хагас богино,нэг оёдолтой ханцуйтай
з.Ар,энгэрийн босоо оруулганд 0.5 см-ийн гоёлын ил оёдолтой
и.Ташааны оёдолд оноотой

й.Ташааны оноонд 1см гоёлын оёдолтой
к.Энгэрт 4н товчтой
л.Ханцуй үзүүр 2см өргөнтэй нугалж оёсон
м.Хормой үзүүр 2см өргөнтэй гуралж оёсон

Эмчийн халат. Зураг 5.

Эмчийн цамц (Зураг 6)
а.Дугуй энгэртэй
б.Энгэр дан зөрлөгтэй, 5-н товчтой
в.Энгэр хажуугаас гарсан босоо релефтэй
г.Энгэрийн босоо релеф 0-5 см-ийн ил гоёлын оёдолтой
д.Энгэрийн доод хэсэгт энгэрийн оруулганд хавчуулж оёсон ил халаастай
е.Ил халаасны ирмэг 0.2 см-ийн нугалж оёсон гоёлын оёдолтой
ё.Ар нь хажуугийн босоо релефтэй
ж.Арын босоо релеф нь 0.5 см-ийн ил гоёлын оёдолтой
з.Хагас богино ханцуйтай
и.Тайлинд сойлттой
й.Сойлт нь 5 см өргөнтэй 2 товчтой
к.Ханцуй үзүүр 5см-ийн өргөнтэй нугалж оёсон
л.Хормой үзүүр 2см өргөнтэй нугалж оёсон

Эмчийн цамц, өмд. Зураг 6

Эмч,сувилагчийн өмд (Зураг 7)

а.Шулуун урт өмд
б. 5см өргөнтэй бүстэй, 5 ширхэг түдүүлтэй
в.Бүсний 2 ташаанд резинэн сойлттой
г.Урд гуяны голын индүүдлэг нь 0.1 см-ийн ил оёдолтой
д.Халаанд 3н товчтой
е.Урд гуяанд 2 хуниастай
ё.Шуумаг 2 см өгрөнтэй нугалж оёсон байна.

Зураг 7

Сувилагчийн цамц (Зураг 8)

а.Гурвалжин энгэртэй
б.Дан зөрлөгтэй.5-н товчтой
в.Энгэр,ар нь босоо релефтэй
г.Хагас богино ханцуйтай
д.Ханцуйн үзүүрт гурвалжин оноотой
е.Мөрнөөс гарсан босоо релефтэй байна.

Зураг 8

Үйлчлэгч ажилтнуудын өмдний загвар, хийцэд дараах зохион бүтээлт, хийцүүдийг тусгасан байна.

Үйлчлэгчийн цамц (Зураг 9)

а.Эргэсэн бартаа захтай
б.Дан зөрлөгтэй,4-н товчтой
в.Хагас богино загвартай цамц
г.Энгэрийн доод хэсэгт ташааны оёдолд оруулсан ил халаастай
д.Хагас богино,нэг оёдолтой ханцуйтай
е.Ханцуй үзүүр 3 см-ийн өргөнтэй манжеттай
ё. Манжетыг сойдог товчтой.
ж.Энгэрт хөндлөн оруулагатай
з.Энгэр босоо релефтэй,гоёлын оёдолтой
к.Арын голоор оёдолтой
л.Ар босоо релефтэй
м.Энгэр,бартаа зах нь гоёлын ил оёдолтой
н.Хортой 2см өргөнтэй нугалж оёсон

Зураг 9.

Үйлчлэгчийн өмд (Зураг 10)

а.Шулуун өмд
б.Өмдний дээд резинэн бүстэй
в.Өмдний суудал нь өндөр

Зураг 10.Үйлчлэгчийн өмд

Үйлчлэгчийн гадуур өмсөх зузаан цамц (Зураг 11)
а.Сүлжмэл материалтай
б.Задгай энгэртэй,цахилгаантай
в.Босоо захтай
г.Цахилгаантай халаастай

Зураг 11

3. Ажлын тусгай хувцасны материалд тавигдах шаардлага:

3.1. Ажлын хувцасны өнгө материал нь эрчтэй утсаар саржа, өсгөмөл саржа, диагональ нэхээсээр нэхсэн нэхмэл даавуу байна.
3.2. Хувцасны материал нь эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй. Хүний биед нөлөөлөх химийн бодис, хүчин зүйлгүй. Жишээ нь хөлстэй наалдах үед харшил өгөхгүй.
3.3. Тос нэвчихгүй. Нефть, тос ус нэвтрүүлэхгүй. Хүчилд тэсвэртэй. Хамгаалах чадварыг сайжруулах зорилгоор байгалийн ба хиймэл ширхэгт , түүний холио болон төрөл бүрийн боловсруулалт (ус үл нэвтрүүлэх, тос үл нэвчих) хийсэн материалуудыг хэрэглэнэ.
3.4. Цахилгаанжихгүй. Цахилгаан зайлуулагчтай.
3.5. Амархан бохирдохгүй. Хэрэглээний дараа хялбар цэвэрлэгддэг байх. Цэвэрлэгээний үед болон нойтон боловсруулалтын үед будаг гарахгүй байх.
3.6. Хиймэл болон холиотой ширхэгт агуулсан тусгай зориулалтын хувцасны материалын гадаргуугийн цахилгаанжилтийн эсэргүүцэл нь 10 ОМ-оос ихгүй байна.

Хувцасны материалын физик-хими, физик механикийн шаардлага, үзүүлэлтүүд нь 2-р хүснэгтэд зааснаас багагүй байна.

Ажлын хувцасны өнгө, материалын физик, хими, физик механикийн үзүүлэлтийг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2

Үзүүлэлт, нэгж	**Нэгж**	**Норм хэмжээ**	**Турших стандарт**
Ширхэгийн бүтээгдхүүн Хөвөн Полиэстер	 %	 80-аас багагүй 20	MNS 4010-2009
Эвдрэлийн ачаалал Суурь Хөндлөн	Н	780-с багагүй 650с багагүй	MNS 1835-6: 2007
Эвдрэл тэсвэрлэх чадвар - Суурь Хөндлөн	Н	51-с багагүй 36с багагүй	MNS 1835-6: 2007
Угаалт тэсвэрлэх чадвар - Ноосон даавуу - Хөвөн даавуу - Синтетик холиотой	цикл	4500-с багагүй 3500с багагүй 5500с багагүй	MNS 1835-7:2007
Агаар нэвтрүүлэлт -агаарын эзэлхүүн -агаарын хэмжээ	л/цаг см^2 мм/с	800-с багагүй 300-с багагүй	MNS ISO 9237
Ус нэвтрүүлэх чадвар	мм.м.у.б	200-с багагүй	MNS ISO 1835-7-2007
Нойтон боловсруулалтын дараах шугаман хэмжээний өөрчлөлт - Суурь - Хөндлөн утасны дагуу	%	 -3,5с ихгүй +_2.0-с ихгүй	MNS 1835-9:2007
Будгийн тогтвор - угаалт - хөлс - Хуурай үрэлт -органик уусгагч буюу хими цэвэрлэгээнд	балл	4 балл	MNS 4072-88 MNS 4069-88 MNS 4070-88 MNS 4073-88

Нэхээсний нягт Тууш Хөндлөн	тоогоор	 162-оос багагүй 300-с багагүй	MNS 1835-4-2007
Зузаан I.II.IY бүлэг ажилтны хувцас III бүлэг ажилтны хувцас	мм	0.4 –өөс багагүй 0.82 –аас багагүй	MNS 1835-3-2007
Элэгдэл тэсвэрлэлт I.II.IY бүлэг ажилтны хувцас III бүлэг ажилтны хувцас	Эргэлтийн тоо	 20000-с багагүй 25000-с багагүй	ISO-12947-2

4. Ажлын хувцасны хэмжээ авах:

4.1. Биеийн хэмжээг үндэслэн ажлын тусгай хувцасны хэмжээг тодорхойлно.

4.2. Ажлын хувцасны хяналтын хэмжээг хүний өндөр, цээж болон бэлхүүсний тойрогийн уртаар тодорхойлно.

4.3. Хувцасны хэмжээг тогтоохдоо хүн тус бүрээс 2 удаа хяналтын хэмжээг авч гүйцэтгэнэ.

4.4. Хувцасны суултыг хангах хэмжээг пиктограммаар үзүүлэх ба хүний биеийн өндөр, цээжний бүслүүр, бүсэлхийн тойрог, өгзөгийн тойргийн хэмжээг тавьсан байна.

4.5. Өндөр, цээжний болон бэлхүүсний тойргийн уртын хэмжээ 8-р хүснэгтэд заасантай тохирч байна.

4.6. Ажлын хувцасны хэмжээг тэмдэглэх жишээг дараах байдлаар үзүүлэв.

Биеийн хэмжээг үндэслэн ажлын тусгай хувцасны хэмжээг тодорхойлно.

Хувцасны хэмжээний хүснэгт:

Хүснэгт3.

Биеийн өндөр (рост)	Биеийн өндрийн хэмжээний зөвшөөрөх нөхцөл, см	Цээжний тойргийн хэмжээ (размер)	Цээжний тойргийн хэмжээний зөвшөөрөх нөхцөл, см
146,152 158,164 170, 176 182, 188	146....155 155....167 167....179 179....191	88, 92 96, 100 104, 108 112, 116 120, 124 128, 132	86 ... 94 94.... 102 102...110 110....118 118... 126 126....134

<u>Эрэгтэй хүний биеийн хэмжээг авахдаа :</u>

Өндөр

Цээжний тойрог

Бэлхүүс

Гарын урт

Хөлний урт зэрэг хяналтын хэмжээг 3 дахин авна.

<u>Эмэгтэй хүний хэмжээг авахдаа :</u>

Өндөр

Цээжний тойрог
Бэлхүүс
Таазны хэмжээ
Гарын урт
Хөлний урт зэрэг хяналтын хэмжээг 3 дахин авна.

Эрэгтэй хүний хэвийн хэмжээ ба ажлын хувцасны харьцааг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 4

Эрчүүдийн хэвийн хэмжээ	40 42 44 46 48 50 52 54	56 58 60 62 64
Цээжний	80 84 88 92 96 100 104 108	112 116 120 124 128
Өндрийн	158 164 168 171 177 180 182	184 186 186 187 187
Бэлхүүсний	68 72 76 80 84 88 92 98	102 108 112 118 122
Гарын урт	56 57 58 59 60 61 62 63	64 65 66 67 68
Хөлний урт	71 73 74 76 78 79 80 81	82 83 83 83 83

Эмэгтэй хүний хэвийн хэмжээ ба ажлын хувцасны харьцааг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 5

Эмэгтэйн хэвийн хэмжээ	36 38 40 42 44 46 48	Том 50 52 54
Цээжний	84 88 92 96 100 104 110	116 122 128
Өндрийн	168 168 168 168 168 168 168	168 168 168
Бэлхүүсний	66 70 74 78 82 86 92	98 104 110
Таазны	91 94 98 102 105 109 114	120 125 131
Бэлхүүсээс хөлний ул хүртэл хэмжээ	106 106 106 106 106 106 106	106 106 106

Хэвийн бус хэмжээний харьцааг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 6

Туранхай эрэгтэй хэмжээ		Том биетэй хүний хэмжээ	Намхан хүний хэмжээ			Бэлхүүсний хэмжээ
	90 94 98 102	106 110 114	24 25 26 27	28	51	53 55 57 61
Цээжний К	98 92 96 100	104 108 122	96 100 104 108	112	100	104 108 112 120

Өндрийн К	177 180 183 186	188 190 192	168 171 174 176	178	170	172 174 176 179
Бэлхүүсний К	76 80 84 88	92 96 100	88 92 96 100	106	108	112 114 116 130
Гарын урт F	62 63 64 65	66 67 68	59 60 61 62	62	61	62 63 64 66
Хөлний урт F	80 81 82 83	84 85 86	73 74 75 76	77	74	75 76 77 79

5. Цэвэрлэгээ:

Угаалга

5.1.Ажлын тусгай болон энгийн хувцсыг ангийн ба химийн аргаар цэвэрлэх боломжтой байна.

5.2. Ус үл нэвтрүүлэх, ус-тос үл нэврүүлэх, үл цахилгаанжих нэмэлт хамгаалах чадварын үзүүлэлтүүд нь 5 удаагийн угаалтын дараа анхны шинж чанараа хадгалж байх ёстой.

Цэвэрлэгээний дараах хэмжээний өөрчлөлт : **х**имийн болон энгийн цэвэрлэгээний дараа ажлын хувцасны материалын хэмжээний өөрчлөлт урт ба өргөнөөрөө 3 хувиас хэтрэхгүй байна.

6.Тэмдэглэгээ:

6.1. Ажлын тусгай хувцас бүр компанийн нэрийн товчилсон үсгүүдийг тэмдэглэсэн тэмдэглэгээтэй байна.

6.2. Захиалагч талын /**УБЦТС ТӨХК**/ хүсэлтээр алба, салбар, хэлтэс, нэгж, хэсгийн нэр, логог тэмдэглэгээнд оруулж болно.

6.3. Компанийн нэрийн товчилсон үсгүүдийг илэрхийлсэн хүрэмний зүүн энгэр болон ар нуруун дээр 2 газар байрлуулна.

6.4. Тэмдэглэгээ нь нүдэнд харагдахуйц тод бөгөөд ойлгомжтой байх

6.5. Цэвэрлэгээний үйл явцад арилахааргүй байх

6.6. Тэмдэглэгээ нь боломжийн хэмжээний том, тод ойлгомжтой шифрээр бичсэн байна.

6.7. Компанийн нэрийн товчилсон үсгүүдийг хатгамалын машинаар хатгаж оёно.

6.8. Хүрэмний зүүн энгэрт байрлах компанийн нэр бүхий хатгамлыг тагтай халаасны дээр түүнээс 5 мм зайтай оёно.

6.9. Ар нуруун дээр байрлах компанийн нэрийн хатгамлыг биеийн цээж хэсгийг голлуулан байрлуулна.

6.10. Ар нуруун дээр байрлах компанийн нэрийн хатгамлын үсгийн өргөн, өндөр нь 9-р хүснэгтэд заасан хэмжээнд байх ёстой. Үсэг, үг хоорондох зай нь доорх хүснэгтэд заасан хэмжээнд байх ёстой.

6.11. Зүүн энгэрт байрлах компанийн нэрийн хатгамлын үсгийн өргөн, өндөр нь доорх зурагт заасан хэмжээнд байх ёстой. Үсэг, үг, гадна эмжээр үг хоорондох зай нь доорх хүснэгтэд заасан хэмжээнд байх ёстой.
6.12. Үсгийн шрифт нь доорх зурагт үзүүлсэнтэй адил байх ёстой.



Зүүн энгэрт байрлах компанийн нэрийн үг, үсэг, гадна эмжээр үг хоорондох хэмжээ

Хүрэмний энгэрийн тэмдэглэгээний үсгийн хэмжээ.

Хүснэгт 7

Үсэг	Хэмжээ, мм							
	A	B	C	H	M	O	N	F
У	10	2		12				
Б	10	2	6					
Ц	10	2			8		2	
Т	12	2				7	2	
С		2						
Х	10	2						6
К	10	2						6

Энгэрийн тэмдэглэгээний үсэг,үг, эмжээр хоорондох хэмжээ

Хүснэгт 8

Нэр	Хэмжээ, мм					
	L	S	Q	P	D	T
Үсэг хоорондох хэмжээ	-	-	2	-	-	-
Үг хоорондох хэмжээ	-	-	-	10	-	-
Эмжээрийн өргөн	-	2	-	-	-	-
Эмжээрийн өргөн	2	-	-	-	-	-
Эмжээр үг хоорондох хэмжээ	-	-	-	-	3	-
Эмжээр үг хоорондох хэмжээ	-	-	-	-	-	3

Ар нурууны тэмдэглэгээний үсгийн хэмжээ

Хүснэгт 9

Үсэг	Хэмжээ, мм							
	A	B	C	H	M	O	N	F
У	44	15	15	64				
Б	44	15	40	64				
Ц	44	15			40		8	
Т	49	15				42		
С		15		64				
Х	44	15		64				32
К	44	15		64				32

Ар нурууны тэмдэглэгээний үсэг,үг хоорондын хэмжээ

Хүснэгт 10

Нэр	Хэмжээ,мм	
	Q	P
Үсэг хоорондын хэмжээ	5	-
Үг хоорондын хэмжээ	-	15

Бүтээгдэхүүний тэмдэглэгээ

Ажлын тусгай хувцасны үйлдвэрлэгч нь өөрсдийн бүтээгдэхүүний талаар дараах мэдээллийг агуулсан тэмдэглэгээ,шошготой байна.

А. Бүтээгдэхүүний төрөл болон нэр

Б. Хэмжээ, размерын тэмдэглэгээ

В. Тухайлсан стандартын дугаар

Г. Ашиглалтын заавар

Д. Хувцсыг хийсэн материалын гал тэсвэрлэх чадварыг тодорхой заасан байх

Е. Хэрэглээний хязгаарлалт (температурын горим г. м.)

Ё. Ашиглалтын үеийн арчилгааны зааврыг тусгасан байна. Угаах, индүүдэх заавар г.м.